



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/462

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 2019 оны 12 сарын 02–ны өдрийн 10 дугаар хуралдааны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Залуу малчин” дэд хөтөлбөрийн хүрээнд “Алтан хөхийн нэгдэл” хоршоонд “Сарлаг өсгөх” төслийг хэрэгжүүлэх ажилд 20.000.000 төгрөгийг зарцуулсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 20.000.000 төгрөг /хорин сая/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл хөтөлбөр арга хэмжээний 5.9 дахь заалтын санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3.Дээрх арга хэмжээг зориулалтын дагуу зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажав/-д даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

